

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **“21 дүгээр зүйл. Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг томилох, тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа**

21.1. Авлигатай тэмцэх газрын даргыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилно.

21.2. Авлигатай тэмцэх газар дэд даргатай байна. Дэд даргыг Авлигатай тэмцэх газрын дарга томилно.

21.3. Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга энэ хуулийн 19.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

21.3.1. Авлигатай тэмцэх газрын дарга төрийн албанад 15-аас доошгүй жил ажилласан, 45 нас хүрсэн, эрх зүйч мэргэжилтэй, удирдах болон мэргэжлийн ажлын мэдлэг туршлагатай, сүүлийн 5 жил улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй;

21.3.2. Авлигатай тэмцэх газрын дэд дарга төрийн албанад 10-аас доошгүй жил ажилласан, эрх зүйч мэргэжилтэй, гүйцэтгэх болон мөрдөн байцаах ажлын мэдлэг, туршлагатай, сүүлийн 5 жил улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй.

21.4. Авлигатай тэмцэх газрын даргыг нэг удаа улируулан томилж болно.

21.5. Авлигатай тэмцэх газрын даргын бүрэн эрх нь түүнийг томилсон тухай Улсын Их Хурлын шийдвэр гарснаар эхэлж, дараагийн дарга томилогдоноор дуусгавар болно.

21.6. Авлигатай тэмцэх газрын дарга нөхөн томилогдвол түүний бүрэн эрх нь томилогдсон өдрөөс эхлэн энэ хуулийн 21.1-д заасан бүрэн эрхийн үлдсэн хугацааг дуустал үргэлжилнэ.”

**2 дугаар зүйл.** Авлигын эсрэг хуулийн 22 дугаар зүйлийн гарчиг, 22.1, 22.5 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2 дахь хэсгийн “дарга, дэд” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.2, 22.3, 22.4 дэх хэсгийн “, дэд дарга” гэснийг, 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсгийн “, дэд дарга нь” гэснийг тус тус хассугай.

Гарын үсэг